



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.10.31 № 03/5096
танай _____-ны № _____-т


БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН
САНГИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
О.СИЙЛЭГМАА ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам” хэрэгжилттэй холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/522, А/520, А/521 тоот тушаал шийдвэрийг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулалтаар ханган, биелэлтийг тухай бүр нь ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт ³ хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.АЛТАНСҮХ

ATA12938 9115621 9024070581



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/521

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл буцалтгүй тусламж олгох, зээл эргэн төлүүлэх журам"-ын 4.1 дэх хэсэг, иргэн Б.Тэнгисээс ирүүлсэн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тэтгэлэгт хөтөлбөрөөр гадаадад суралцуулах тухай" Боловсролын сайдын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/315 дугаарт тушаалын 58 дэс дугаарт бичигдсэн Бат-Эрдэнэ овогтой Тэнгисийг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн Бүгд Найрамдах Турк Улсад суралцуулсугай.

2. Хавсралтаар баталсан суралцагчидтай сургуулийн суралцах улс, хугацаа, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийг тусгасан гэрээ байгуулж, зохих журам, гэрээний дагуу төлбөр тооцоог цаг хугацаанд шийдвэрлэж, улирал тутам гэрээг дүгнэсэн тайланг танилцуулахыг Боловсролын зээлийн сан (О.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/520

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудитораас 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн "Хариу хүргүүлэх тухай" 2840 тоот албан бичиг, иргэн Т.Намуунаас ирүүлсэн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" А/475 дугаар тушаалын хавсралтын 7 дэс дугаарт бичигдсэн Төрхүү овогтой Намууны мэргэжлийг "Санхүү, эдийн засаг" гэснийг "Өгөгдлийн шинжээч" болгон өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан зохих журмын дагуу гэрээнд өөрчлөлт оруулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу сургалтын төлбөрийг шилжүүлэхийг Боловсролын зээлийн сан /О.Сийлэгмаа/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Л.Төгсбаяр/-т үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР

14251 1502



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/345

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл буцалтгүй тусламж олгох, зээл эргэн төлүүлэх журам"-ын 4.1 дэх хэсэг, иргэдээс ирүүлсэн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тэтгэлэгт хөтөлбөрөөр гадаадад суралцуулах тухай" Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/345 дугаарт тушаалын нэгдүгээр хавсралтын 3 дэс дугаарт бичигдсэн Амгаланбаатарын Мөнх-Оргилын суралцах улс "Америкийн Нэгдсэн Улсын Пурдю их сургууль" гэснийг "Австралийн Холбооны Улсын Сидней их сургууль" гэж өөрчилсүгэй.

2. "Тэтгэлэгт хөтөлбөрөөр гадаадад суралцуулах тухай" Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/345 дугаарт тушаалын гуравдугаар хавсралтын Бүгд Найрамдах Литва Улс гэсний "1, 2, 4 дэс дугаарт бичигдсэн суралцагчдыг Унгар Улс гэсэн хэсэгт", "3, 5 дэс дугаарт бичигдсэн суралцагчдыг Бүгд Найрамдах Турк Улс гэсэн хэсэгт оруулж тус тус өөрчилсүгэй.

3. Хавсралтаар баталсан суралцагчидтай сургуулийн суралцах улс, хугацаа, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийг тусгасан гэрээ байгуулж, зохих журам, гэрээний дагуу төлбөр тооцоог цаг хугацаанд шийдвэрлэж, улирал тутам гэрээг дүгнэсэн тайланг танилцуулахыг Боловсролын зээлийн сан (О.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР

14251 1498